



## ШОТЛАНД УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Эрүүгийн хэрэг<sup>1</sup>)

### ХЭД ХЭДЭН УДАА ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДСЭН ХҮНД ХӨНГӨН ЯЛ ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХГҮЙ

**САНАМЖ:** Энэхүү хураангуй хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

**Шүүхийн шийдвэрийн дугаар:** 2025 HCJAC 23

**Шүүхийн шийдвэрийн огноо:** 2025 оны 05 дугаар сарын 21-ны өдөр

**Шийдвэрийн төлөв:** Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

### ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч Kyle Beveridge нь 2013 оноос 2021 оны хооронд хамтран амьдарч байсан А, Б, С-г удаа дараа айлган сүрдүүлж, доромжилж, тэдний хувийн мэдээлэл болон зургийг олон нийтэд тараахыг заналхийлсэн, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн болон бэлгийн хүчирхийлэл үзүүлсэн гэх гэмт хэрэгт холбогджээ.

### ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Шотланд Улс гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль (2018)<sup>2</sup>, Эрүүгийн хууль (1995)<sup>3</sup> зэргийг үндэслэн хариуцлага оногдуулдаг. Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн нэгдүгээр хэсгийг (section 1) үндэслэн хамтран амьдарч байгаа, гэр бүлийн хамааралтай хүн эсхүл урьд өмнө гэр бүлийн хамааралтай байсан хүнийг доромжлох, айлган сүрдүүлэх, хянах зэрэг үйлдэлд 14 хүртэлх жилийн хорих ял оногдуулах зохицуулалттай. Мөн хүчиндэх гэмт хэрэгт холбогдсон этгээдэд бүх насаар нь хорих ялыг оногдуулах боломжтой байдаг.

Дээрх гэмт хэргийн хувьд прокуророос шүүгдэгчид "... 8 жил дараалан үргэлжилсэн үйлдлээр хохирогчдыг байнга дарамтлах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, айлган сүрдүүлэх зэрэг үндэслэлээр эрүүгийн хариуцлага оногдуулах..." санал гаргасан. Анхан болон давж заалдах шатны шүүхээс шүүгдэгчид 12 жил хорих ял, хорих ял эдэлж дууссаны дараа 4 жил хяналтад байлгах шийдвэрийг гаргасан байна. Шүүгдэгч, түүний өмгөөлөгч уг шийдвэрийг эс зөвшөөрч хяналтын шатны шүүхэд гомдол гаргажээ.

<sup>1</sup> Шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://www.scotcourts.gov.uk/media/tlonm2sf/2025hcjac23-appeal-against-conviction-and-sentence-by-kyle-beveridge.pdf>

<sup>2</sup> Domestic Abuse Scotland Act (2018)

<sup>3</sup> Criminal Law (Consolidation) Scotland Act (1995)

**Шүүгдэгч, түүний өмгөөлөгчөөс гаргасан гомдолд:** “... Шүүхийн шийдвэр хэргийн бодит байдалтай нийцээгүй, шүүгдэгч бэлгийн хүчирхийлэл үйлдсэн гэх хангалттай нотлох баримт хэрэгт авагдаагүй. Мөн шүүгдэгч гэмт хэрэг үйлдэж эхлэх үедээ 17 настай байсан ба 24 нас хүрээгүй байсан. Түүний нас, сэтгэлзүйн хувьд бүрэн төлөвшөөгүй байдал зэргийг шүүх харгалзан үзэх ёстой буюу анхан болон давж заалдах шатны шүүхийн оногдуулсан эрүүгийн хариуцлагыг 25, түүнээс дээш насны хүнд оногдуулах нь зохистой байсан” гэж дурджээ.

**Хяналтын шатны шүүхээс дараах шийдвэрийг гаргасан байна:**

1. Шүүгдэгч хамтран амьдрагчдаа хүч хэрэглэн бэлгийн харилцаанд орсон гэх хэрэгт хангалттай нотлох баримт шаардлагатай буюу нэг нотлох баримтыг өөр нотлох баримтаар давхар нотолж байх нь зүй ёсны хэрэг юм. Хохирогч эмэгтэйчүүдийн мэдүүлгийг харьцуулан үзэхэд гэмт хэргийн шинж ижил төстэй байсан, үргэлжилсэн үйлдэл ажиглагдах бөгөөд энэ нь нэг хохирогчийн мэдүүлэг нөгөө хохирогчийн мэдүүлэгт харилцан баталгаа болж давхар нотолгооны стандарт хангагдаж буй үндэслэл болно. Үүнийг харилцан баталгаа болох буюу “*Mutual corroboration*”, “*Moorov doctrine*” гэж нэрлэнэ.
2. Хохирогчийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан талаар өмнө нь удаа дараа өөрийнх нь ярианаас сонсож байсан гэх хүмүүс байх бөгөөд **тэдний мэдүүлгийг шүүхээс шууд нотлох баримт гэж үзэх боломжгүй**. Түүнчлэн дам ярианы нотолгоо буюу “Hearsay” нь зөвхөн хохирогчийн өгсөн мэдүүлгийн (найз нөхдөдөө хүчирхийллийн талаар өмнө нь хэлж байсан гэх мэт) үнэн, зөвийг баталгаажуулж буй хэлбэр юм. Тиймээс шууд нотлох баримт болохгүй юм.
3. Гэр бүлийн хүчирхийлэл гэж үзэхэд шүүгдэгчийн нэг удаагийн үйлдэл бус удаа дараагийн давтагдсан үйлдэл байх ёстой. Өөрөөр хэлбэл “Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль”-д зааснаар хохирогчийг удаа дараа, тогтмол доромжлох, сүрдүүлэх, айдаст автуулах, хүчирхийлэх үйлдлүүд нийлээд нэг гэмт хэргийн бүрэлдэхүүн болно.<sup>4</sup> Энэ нь шүүгдэгчийн хамтран амьдрагчдаа олон жилийн турш сэтгэлзүйн дарамт үзүүлэх, айлган сүрдүүлэх, бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл үзүүлэх, өөрийн хяналтдаа байлгасан зэргээр нотлогдож байна.
4. Шүүгдэгч нь 2013 оноос 2021 он хүртэл гэмт хэргийг удаа дараа үйлдэж байсан нь үргэлжилсэн үйлдэлт гэмт хэрэг гэж үзэх бөгөөд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг болон бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг хамтад нь үйлдсэн байхыг нийлмэл гэмт хэрэг үзнэ.
5. Шүүхээс “...шүүгдэгч насны хувьд залуу хэдий ч гэм буруугийн хувьд үүнээс илүү давсан асуудал байна. Тодруулбал, нэг хохирогч бус гурван хохирогчийг олон жилийн турш дарамталсан нь төлөвшөөгүй хүний хийх үйлдэл биш буюу өөрийн гэсэн ухамсартай, зөв, бурууг ялгаж сурсан хэдий ч үүнийг хүсэж, төлөвлөж, давтаж үйлдэхийг хүссэн хүний үйлдэл байна. **Гэм бурууг шүүгдэгчийн наснаас илүүтэйгээр буруутай үйлдлийн шинж чанараар хэмжинэ** гэсэн давж заалдах шатны шүүхийн дүгнэлт үндэслэлтэй байна...” гэжээ.

<sup>4</sup> Domestic Abuse act(2018), section 1.



6. Онолын хувьд өсвөр насны хүн сэтгэл зүйн болон насны хувьд “*Immaturity vs. Culpability*” буюу төлөвшөөгүй байдаг гэх хандлага байгаа хэдий ч Шотланд Улсад 17 насанд хүрсэн хүн эрүүгийн хариуцлага хүлээх боломжтой гэж үздэг.
7. Шүүхээс шүүгдэгчид үндсэн хорих ялыг 12 жилийн хугацаатайгаар оногдуулж, extended sentence<sup>5</sup>-ийг 4 жилийн хугацаагаар тогтоосон нь шүүгдэгчийн гэм буруутай үйлдэлд тохирсон байна.
8. Хяналтын шатны шүүхээс шүүгдэгч, шүүгдэгчийн өмгөөлөгчийн гаргасан гомдлын бүхий л үндэслэлийг үгүйсгэж, гомдлыг хүлээж авахаас татгалзаж “Гэр бүлийн хүчирхийлэл” үйлдсэн этгээдэд оногдуулсан эрүүгийн хариуцлага нь түүний гэм буруутай үйлдэлд тохирсон, хуульд нийцсэн байна гэж дүгнэжээ.

---o0o---

---

<sup>5</sup>Энэ нь Шотландын Эрүүгийн шүүхийн онцлог зохицуулалт бөгөөд үндсэн 12 жилийн хорих ялыг эдэлж дууссаны дараагаар 4 жилийн хугацаанд хяналтад байхыг ойлгоно. Хяналтыг тус улсын Пробацын алба хариуцна. Шүүхээс хяналттай хугацаанд нэмэлтээр тодорхой нөхцөлүүдийг тавьж болдог (ж.ш архи согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, тодорхой хүнтэй уулзахыг хориглох г.м) байна.